

<https://doi.org/10.65816/jsds.2025.04.012>

Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх - улс орны батлан хамгаалах чадавхыг бүрдүүлэгч асуудлын нэг болох нь

С.Пүрэвдорж

*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Цэргийн урлаг судлалын төв*

ABSTRACT

The form, content, and nature of the current threat of aggression are changing. The competition and confrontation between great powers to maintain their global competitiveness is taking place in the form of “unconventional wars” and “combination wars” that are different in appearance, content, and nature from those of the past. These “unconventional wars” and “combination wars” are creating the basis for small and underdeveloped countries to face various challenges.

Based on the experience and lessons learned from countries affected by “unconventional wars” and “combination wars,” there is a need and a need to build and increase national defense and resistance capabilities. Since building national defense and resistance capabilities is a strategic, long-term, state and public participation, and a national-scale issue, there is a need and a need to direct research and analysis work to it. At the same time, the national defense and resilience capacity can only be achieved based on patriotism and education, so it is necessary to create a state policy and legal environment.

Keywords: *National defense resilience; unconventional threats; military power and capabilities; local defense; patriotic nationalism; socio-psychological preparation of the people.*

ҮНДСЭН ХЭСЭГ

Өнөө үеийн эзлэн түрэмгийллийн аюул заналхийллийн хэлбэр, агуулга, шинж чанар хувьсан өөрчлөгдөж байна. Дэлхийд өрсөлдөх чадвараа хадгалахын төлөөх их гүрнүүд хоорондын өрсөлдөөн, сөргөлдөөн нь урьд өмнөх үеийнхээс гадаад төрх, агуулга, шинж чанараараа ялгаатай “уламжлалт бус дайн”, “хосолмол дайн”-ы хэлбэрээр явагдах боллоо. Энэхүү “уламжлалт бус дайн”, “хосолмол дайн” нь жижиг, хөгжил буурай улсуудад олон янзын сорилтой тулгарах үндсийг бүрдүүлж байна.

“Уламжлалт бус дайн”, “хосолмол дайн”-д өртөж буй улс орнуудын туршлага, сургамжид үндэслэн үндэсний батлан хамгаалах эсэргүүцлийн чадавхыг бүрдүүлэх, нэмэгдүүлэх шаардлага, хэрэгцээг бий болгож байна. Үндэсний батлан хамгаалах эсэргүүцлийн чадавхыг бүрдүүлэх нь стратегийн шинжтэй, урт удаан хугацаа, төр, олон нийтийн оролцоо, үндэсний хэмжээний асуудал болж буй

тул судалгаа, шинжилгээний ажлыг түүнд чиглүүлэх шаардлага, хэрэгцээг бий болголоо. Үүний зэрэгцээ үндэсний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавх зөвхөн эх оронч үзэл, хүмүүжилд тулгуурлан хангагдах учир төрийн бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэхийг шаардаж байна.

Сүүлийн үеийн дайн, байлдаан, зэвсэгт мөргөлдөөн, сөргөлдөөний хэлбэр, агуулга, шинж чанарын илрэлийг харахад, дэлхийн олон улс, эвсэл, холбоотон, түнш бүхий улсууд тухайлбал: ЗХУ, АНУ-ын Афганистан дахь; Исламын улс бүлэглэлийн Ирак, Сири дэх; Хезболлын Иран, Ливан дахь; Хамасын Газын зурвас дахь; Барууны улс орнуудаас Ирак, Ливи, Югослав дахь байлдааны ажиллагаа; 2007 оны Эстони дахь цахим засаглал, харилцаа холбооны сүлжээ, веб сайтууд дахь Оросын хакеруудын дайралт; ОХУ-ын Крымд явуулсан ажиллагаа; Украин дахь Оросын зэвсэгт хүчний цэргийн тусгай ажиллагаагаар улсынхаа үндэсний аюулгүй байдлыг хангахдаа хувь хүмүүс, байгууллага, бүх ард нийтийн эсэргүүцлийн хүчний оролцоонд тулгуурлан гаднын бодит дарамт шахалт, түрэмгийлэл, нөлөөллийг тэсвэрлэх, өөрийн улсын дотоод дахь шударга бус үйлдлийн эсрэг тэмцэж буй эх орончдын үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхаар тэдний эсрэг явуулж буй үйл ажиллагааг дурдаж болохоор байна.

Чухамхүү энэ нөхцөл, хүчин зүйлсийн нөлөө нь улс орны батлан хамгаалах үүрэг зорилтыг стратегийн түвшинд улсын сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх бодлого, үзэл баримтлалын тогтолцоог онол, арга зүйн үндэслэлтэй боловсруулахыг нөхцөлдүүлж байна гэж үзэж байна.

Нэг. Эх оронч Монгол хүний (хувь хүмүүс) оролцоонд тулгуурлан үндэсний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх нь

Өнөө үед ямар нэгэн аюул заналхийлэлтэй олон нийт, ард иргэдийн оролцоотой тэмцэх үндэсний хэмжээний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавх, бэлэн байдлыг хангах, тэдгээртэй тэмцэхэд мэргэжлийн хувьд чиглүүлэх үүрэг хүлээсэн байгууллага, салбар, нэгжүүд өөр өөрийн өнцгөөс олон янзаар, явцуу салангид ойлголтыг бий болгож байгаа учир аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагааг нэгдсэн ойлголтын хүрээнд авч үзэх нь чухал байна.

Тухайлбал: “эсэргүүцэх чадавх” гэсэн нь ямар нэгэн хүчний болон байгууллагын эсрэг чиглэсэн, түүнийг няцаах, эсэргүүцэх үйлдлийн боломж, чадавх, зэргийг илэрхийлдэг ерөнхий нэр томьёо юм. Харин цэргийн ажиллагааны хувьд дайсны цэргийн хүчний эсрэг явуулах байлдааны ажиллагааны боломж; нийгмийн шинжлэх ухаанд эзлэгдсэн улс орны сөрөг хүчин - партизаны хөдөлгөөн, дайн явуулах чадамж гэх мэт утгаар илэрхийлэгдэх болохыг судлаачийн зүгээс харж байна.

Сүүлийн үед үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг талаас нь “эсэргүүцлийн хүч”, “сөрөн тэсвэрлэх чадавх” гэсэн нэрээр хэрэглэж, онол, практикийн шинжилгээ, судалгааг явуулах нь өргөжиж боллоо.

Монгол Улсын нийгэм, улс төрийн байдал, бүс нутгийн цэрэг, улс төрийн нөхцөл, хүрээлэн буй орчин нөөлөлтэй уялдуулан “сөрөн тэсвэрлэх чадавх”-ыг

“гаднын бодит болон бодит бус дарамт шахалт, түрэмгийлэл, нөлөөллийг тэсвэрлэх, улс үндэстнийхээ тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хадгалах, өөрийн улсын дотоод дахь шударга бус үйлдэл, баялгийн шударга бус хуваарилалт, авлига, улс төр бизнесийн бүлэглэлийн эсрэг тэмцэх олон нийтийн хүсэл эрмэлзэл, чадварын нэгдэл” гэсэн байдлаар судалж үзэх боломжтой байна.

Тэгэхдээ уламжлалт бус аюул занал ихсэж, түүнийг эсэргүүцэх, сөрөн тэсвэрлэх чадварыг бүрдүүлэх чиглэлд судалгаа, шинжилгээний ажлыг явуулах нь хязгаарлагдмал байлаа.

Өнөөгийн нөхцөлд дайн, байлдааны ажиллагаанд хүч тэнцвэргүй ажиллагаа голлох болж, уламжлалт хүч хэрэглэсэн дайн, байлдаан цөөрч, аль болохоор шинэ уламжлалт бус стратеги - тактикийн аргыг хэрэглэх боллоо. Энэ нь дайныг “төр, улс биш тоглогчид, бүлэглэл” явуулах нь нийтлэг байгаад үндэслэн хувь хүмүүс, байгууллага, бүх ард нийтийн эсэргүүцлийн хүч, оролцоонд тулгуурлан эх оронч үзлийг үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхтай уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай болсныг харуулж байна.

Дэлхийн бүх улс үндэстэнд “ашиг, сонирхол” хэмээх мөнхийн асуудал оршин байх бөгөөд түүндээ нийцүүлж төрийн бодлого, үзэл баримтлалаа боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэх стратегийг гаргадаг. Зарим улс оронд, тухайлбал, АНУ-д Үндэсний аюулгүй байдлыг хангах стратегидаа¹:

- Америкийн ард түмэн, америкийн амьдралын хэв маягийг батлан хамгаалах;
- Америкийн хөгжил цэцэглэлтийг хангах;
- албадлагын хүч, арга тактикаар энх тайван байдлыг хадгалах;
- Америкийн нөлөөллийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх асуудлыг тусгасан байна.

Америк мэт дэлхийн хүчирхэг гүрэнд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх бодлого, үзэл баримтлалын талаарх асуудал гэж байдаггүй юм байна.

Харин судлаачийн үүднээс харахад, жижиг, хөгжил буурай улс болон их гүрэнтэй улсын хил нь залган хөрш байдлаар оршдог улс; тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд нь гаднын түрэмгийллийн заналд оршиж буй улсад үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх асуудлыг ард нийтийнхээ хүч оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэхийг зорилгоо болгож байна.

Улс үндэстний хувьд, “эх орон”, “нутаг дэвсгэр” гэсэн ойлголт чухал байна. Газар нутаг - улс оршихын үндэс болдог. Энэ газар нутагт үе дамжин амьдарсаар ирсэн ард түмний язгуур эрх, ашиг сонирхол, ёс суртахуун, хүмүүнлэг ёс, үнэт зүйлсийн цогц нэгдэл, олон мянган жилээр цогцлуулж бүрдүүлсэн амьдралын хэв маяг, зан заншил, соёл, иргэншил, нийгмийн тогтолцоо, эдийн засгийн хэв шинж, нутгийн захиргаа, өөрийгөө удирдах ёс, байгуулж босгосон бүтээн байгуулалт, хөрөнгө, баялаг, нөөц бол “эх орон” бөгөөд түүний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал монгол хүн бүхэнд хамгаас үнэ цэнтэй нь болж байдаг. Тиймээс эх орны газар нутаг, хилийн халдашгүй бүрэн эрхт байдал хангагдаж байхын төлөө бүтээн

¹ *Cyberwarfare, CRS Report for Congress, RL 30735, Nov. 15, 2000;*

цус, халуун амь, залуу насаа зориулан тэмцэх нь батлан хамгаалах үндэсний сөрөн тэмцэх чадавхын үндэс байх болно.

Дэлхийн улс орнууд олон төрөлт стратегиар батлан хамгаалах зорилтоо хэрэгжүүлж, аюулгүй байдлаа хангаж байна².

Олон улсын цэргийн эвсэл, холбоонд нэгдэх замаар, тухайлбал: Европын ихэнх улсууд НАТО-ын эвсэлд элсэж, зарим нь цэргийн тэргүүлэх гүрний ивээл, халамжид багтах аргаар, жишээ нь, Ази, Номхон далайн бүс нутгийн тэргүүлэх хөгжилтэй Япон, БНСУ, Австрали, Шинэ Зеланд, Тайвань зэрэг улс АНУ-тай байгуулсан хоёр болон олон талт гэрээ хэлэлцээрээр их гүрний “далбаа” дор аюулгүй байдлаа бэхжүүлэн батлан хамгаалах зорилтоо хэрэгжүүлж байна.

ЗХУ задран олон тусгаар улс болж, зарим улсууд Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл (ТУХН)-ийн улсуудын хамтын ажиллагаанд; Хамтын аюулгүй байдлыг хангах гэрээний улс (ХАБХГУ)-ууд Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага (ХАБГБ); Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ), Азийн хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх зөвлөгөө (АХАИБЗ)-нд нэгдэх замаар улсынхаа аюулгүй байдлыг “Хамтын батлан хамгаалах тогтолцоо”-нд тулгуурлан батлан хамгаалах үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх бодлого, үзэл баримтлалыг бүрдүүлэх боломжийг нэмэгдүүлэх боллоо.

Гэхдээ л бүс нутагт аль улс тэргүүлэгч байх, нүүрс устөрөгчийн гаралтай эрчим хүчний зах зээлийн өрсөлдөөнд хэн давамгайлах гэгээд улс төрийн хийгээд эдийн засгийн олон асуудал амар хялбар шийдэгдэхгүй байгаа нь тухайн улсын үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхтай холбогдолтой юм.

Хэрэв Төв Азийн зарим орнуудад төр, засгийн удирдлагын улс төрийн хийгээд эдийн засгийн сөргөлдөөн цаашид даамжирч, тэдгээр улс орны эдийн засгийн байдал улам доройтох аваас иргэдийн дунд эсэргүүцлийн эгнээ өргөжиж, тэд төр, засгийнхаа эсрэг хэт туйлширсан зэвсэгт бүлэглэлийн эгнээн тэлэх аюул байсаар байгааг сэрэмжлүүлэх нь чухал байгаа юм.

Монгол Улс ард иргэдийн хүч оролцоотойгоор орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах стратегиар тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хангах гэсэн бодлого, үзэл баримтлалтай улсын нэг нь юм. Хэдийгээр манай улс том газар нутагтай, хөгжлөөр буурай, эдийг засгийн чадавхаар жижиг улс боловч их гүрнүүдийн хүрээлэл дор, айх аюул бага, энх тайван ч гадаад бодлого баримталж, НҮБ-ын энхийн үйлсэд боломжийн хэрээр өөрийн хувь нэмрийг оруулж, улс төр, дипломатын аргаар аюулгүй байдлаа хангах замаар батлан хамгаалах зорилтоо хэрэгжүүлсээр байна. Энэ нь Монгол Улсын бүрэн эрхт байдлыг бүрэн байлгаж, аюулгүй байдлаа хангаж буй илэрхийллийн асуудал биш юм. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг³ - т тодорхойлсноор: нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаагаар улс орноо

² Батлан хамгаалах стратеги. (онол, арга зүй, шинжилгээний бүтээл). УБ., 2017 он. – 400 х; т.106-107;

³ Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. Заалт 1.2 ба 2.1, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт;

батлан хамгаалах болно гэж заасан байдаг.

Сүүлийн үед улс орнуудын бүрэн эрхт байдал нэлээд тохиолдолд эргэлзээ төрүүлэхээр хямралт байдалд хүрч байсныг зарим баримтаар жишээ авч үзье. Казахстан улсад 2022 оны 1 дүгээр сард дэлхий нийтийг цочирдуулсан үйл явдал болж, “Шингэрүүлсэн хийн” үнэ хоёр дахин нэмэгдсэнд бухимдсан ард иргэд, олон нийт эсэргүүцэн жагсаж, үйл ажиллагаа нь олон хот руу халдварлан тэлж хүний амь эрсдэж, төр, бизнесийн байгууллагад асар их хор хохирол учруулсан эмх замбараагүй байдал болж үргэлжилсэн⁴ юм. Энэ нь Казахстан улс тусгаар тогтносон улс мөн боловч, эдийн засаг болон мэдээллийн аюулгүй байдлын хувьд бүрэн эрхт байдал нь ихээхэн суларч, гадаадын үндэстэн дамнасан корпорацуудын хөрөнгө оруулалтын үр дүнгийн хуваарилалт шударга бус, үндэсний эдийн засгийн үндсэн салбаруудын харьцаа, хэв шинж алдагдсан, үүнээс болж ажилгүйчүүдийн тоо нэмэгдсэн, ялангуяа залуучуудын болон нийт ард иргэдийн дотор баян, ядуугийн зааг ялгаа ихэссэн, цөөн хэдэн улс төр, бизнесийн бүлэглэлд үндэсний баялаг төвлөрсөн, хуурамч мөнгө, авлига, далд эдийн засаг, хар захын бохир үйл ажиллагаа ихэссэн зэргээс шалтгаалж үндэсний эдийн засаг нь хараат байдалд орсноос үүдэлтэй гэж үзэж байна.

1980-аад оноос “Европ-нэг орон гэр” хэмээх хөдөлгөөн өрнөж, эдүгээ 30 гаруй улс Европын Нэгдсэн Холбоонд багтан орсноор тэдгээрийн хооронд хил хязгаарын нарийн зааггүй, визгүй зорчдог, евро хэмээх нэгдсэн мөнгөн тэмдэгтэй, Евро парламент хэмээх төвлөрсөн байгууллагатай, нэгдсэн үндсэн хуультай болох төлөвийг буй болгосон билээ. Харин Азийн улс, орнуудын хувьд нэлээд алс ирээдүйн шинжтэй төлөв ажиглагдаж байна. Ийм нөхцөлд эх оронч үзлийн хуучин ойлголт агуулга, хэлбэрийн хувьд өөрчлөгдөж, хэд хэдэн янзын хэв маягийг бүрэлдүүлж байна. Тухайлбал:

- Уламжлалт эх оронч үзэл нь түүхэн ёсоор тогтсон эх орны хилийн дээсний хүрээнд ээнэгшин найрсаж, үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэж явсан баатар жанжин, цэрэг эрсийнхээ баатарлаг дайчин уламжлал, гол төлөв эх түүх, соёл, хэл, заншлаараа бахархах явдалд суурилсан үнэт зүйлсийн цогц болой. Энэ нь их төлөв хөгжиж байгаа орнуудад нэлээд тогтвортой, дархлаажсан шинжтэй байна. Эдгээр орнуудад төр засгаас эх оронч үзлийг цэрэг-эх оронч үзлийн үүднээс илүү төлөвшүүлэх бодлого явуулдаг. Ялангуяа өнгөрсөн үеэрээ бахархах, түүхэн уламжлалаа хадгалах эрмэлзэл давуутай байна;
- Эдүгээгээс эх оронч үзэл нь дэлхий дахины болон үндэсний үнэт зүйлсийн харилцан шүтэлцээнд тулгуурласан иргэнлэг, ардчилсан, хүмүүнлэг шинжийг илүү агуулж байна. Өдгөө эх оронч үзэл нэгэн улсын хүрээнээс хальж, нэг тив, нэг бүс нутаг-нэг гэр орон, улмаар энэхэн замбуулин-бидний өлгий нутаг хэмээн ярьж, бичиж задгайрах хандлагыг агуулж байна.

Даяаршил улам бүр түгж буй өнөө үед аль нэгэн улс орон өөрийн аюулгүй байдлыг дангаараа буюу бие даан хангах, батлан хамгаалах бодлого, зорилгоо

⁴ *Необходимое разъяснение к происходящим в Казахстане событиям – Avesta – информационное агентство;*

хэрэгжүүлэх боломж нь хязгаардагдаж буй нь улс орнуудын батлан хамгаалах асуудал тухайн улс орны сөрөн тэсвэрлэх эдийн засгийн чадавхтай шууд хамааралтай болох нь тодорхой. Өөрөөр хэлбэл аливаа улс орны эдийн засгийн хөгжлийн боломжоос тухайн улсын аюулгүй байдал, батлан хамгаалах асуудал бүхэлдээ хамаарч, нийт иргэдийн эх орноо гэсэн сэтгэл, үзэлд тулгуурлах болжээ.

“Өөрийгөө батлан хамгаалах” үзэл баримтлалаар бол улсынхаа газрын болон агаарын хилийн хамгаалалтыг найдвартай байлгахаас эхлэх ёстой болж байгаа юм. Гэтэл газрын ч, агаарын ч, хилийн хамгаалалт өнөө үед тавьж байгаа шаардлага, хэрэгцээнд тэр бүр нийлж чадахгүй байгаа нь батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг ард иргэдийн эх оронч сэтгэлгээ, үзэл төлөвшлийн асуудалтай шууд холбоотой гэж үзэж болохоор байна.

Өнөө үед улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх”⁵, “хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай, үндэсний үзэл, хүмүүжилтэй эх орон ч монгол хүн”⁶-ийг төлөвшүүлэх нь нэн чухал болоод байна. Энэ нь нийгмийн оршин тогтнох, түүний сайн сайхан байдал, тогтвортой хөгжил, соёлын өвөрмөц байдал, түүний хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх, тусгаар тогтнолыг хангах чадвар, дэлхийн хамтын нийгэмлэгт улс орныхоо статусыг хадгалах чадварын илэрхийлэл болж байна.

Дээрхээс харахад, үндэсний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадвар бүхий эх оронч сэтгэлгээтэй хүмүүсийг бүрдүүлэхийн тулд:

Нэгд, ажил хаялт, бослого, хөдөлгөөн өрнөх угтвар нөхцөл байдал бүрэлдэж байгаа эсэхэд үнэлгээ, дүгнэлтийг тогтмол хийж байх нь чухал. Мэдээлэл-технологи хөгжсөн энэ үед ард иргэдийн амьжиргааны эх сурвалж болох нийгмийн асуудлаа зөв өнцгөөс харж, хугацаа алдалгүй шийдэхгүйгээс батлан хамгаалах аюулгүй байдлаа ганхуулж гадныхны өгөөш болох эрсдэлийг үүсгэж болзошгүй байна.

Хоёрт, бүрэн эрхт тусгаар улс, үндэстэн доторх үймээн, самууныг болон террорист үйл ажиллагааг зохион байгуулалттайгаар гаднаас ажиглаж байгаа нь дамжиггүй. Тэдгээрт гаднын дэмжлэгийг гадаадын санхүүжилттэй төрийн бус байгууллагаар, гаднын хөрөнгө оруулалтаар дамжигдана ирж болзошгүй байна.

Гуравт, ардчиллын үйл явцыг үгүйсгэх, авлига, хээл хахууль нэмэгдэх, баялгийн тэгш бус хуваарилалт, шударга бус байдал дэлгэрэх зэргээс үүдэлтэй иргэдийн бухимдал нь тэднийг улс төрийн эсэргүүцэлд оролцох ажиллагааны эх сурвалж болж байна. Жишээлбэл: 2008 онд Монголд; 2014 онд Украинд; 2020 онд Беларус; 2021 онд Казакстанд өрнөсөн олон нийтийн эсэргүүцлийн жагсаал, зэвсэгт мөргөлдөөний үйл явдал нь дэг татуурт нэгэн удирдлагад төвлөрсөн дэглэм, авлига, тэгш бус байдал, шударга бус үйлдлийн үр дүн гэж үзэж болно.

Дөрөвт, улс үндэстэн дотроо арга эвээр учраа олж, төр засаг нь сөрөг хүчинтэйгээ хэлэлцээ хийж, олон нийтийн тавьсан хүсэлт, шаардлагад ухаалгаар

⁵ Монгол Улсын үндсэн хууль. УБ., 1992 он. Үндсэн хуулийн оршил хэсэг дэх заалт;

⁶ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Зорилт 1.2. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн. 1 үе шат (2021-2030): Нэг дэх заалт;

хандаж чадаагүйгээс улс үндэстэн салан тусгаарлах байдлаар тэмцэл зөрчилдөөнийг үүсгэхэд хүргэдэг гашуун сургамжид дүгнэлт хийж ажиллах нь чухал байна.

Тавд, хэт үндсэрхэг үзэл болон шашин хоорондын тэрс үзэл, террорист халдлага, газар нутгийн маргаан, салан тусгаарлах үзэл, олон жилийн туршид шийдэгдээгүй бугшсан асуудалд төр засаг онцгой анхаарч ажиллахыг нөхцөлдүүлж байна гэж үзлээ.

Хоёр. Төр, олон нийтийн байгууллагын зохион байгуулалтаар батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх нь

Монгол Улсад үндэсний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх нь: нэгд, “Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцох”⁷, “сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрх, ... олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх”⁸, “эх орноо хамгаалах”⁹, “хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй”¹⁰ зэрэг заалтад үндэслэн эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх асуудлыг төрийн болон төрийн бус байгууллага, бүх нийтэд сурталчлан хэвшүүлэх нь чухал байна.

Улс үндэсний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх нь цэргийн хүч, чадавх төдийгүй иргэний нийгмийн байгууллагуудыг хамааруулж, цаашид иргэд, олон нийтийн өргөн дэмжлэг, оролцоонд тулгуурлан улс орныг батлан хамгаалах тухай ойлголтыг агуулж байна.

“Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа болно”¹¹ гэсэн Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг дэх заалттай нийцүүлж, улсын батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэн бэхжүүлэх нь чухал болох юм.

Сөрөн тэсвэрлэх чадавх ба үндэсний эсэргүүцлийн ажиллагааг улсын үндэсний аюулгүй байдлыг хангах болон батлан хамгаалах тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг болон өргөжүүлэн, төлөвшүүлэн бүрэлдүүлэх үйл явц нэн тулгамдсан асуудал байхаар төсөөлөгдөж байна.

Үндэсний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг чухалчлан бүрдүүлэх нь төрийн бодлого, хууль эрх зүйн талаасаа гадаад, дотоод цэрэг, улс төр, эдийн засгийн нөхцөл байдлаас хамааралтай байна. Иймээс жижиг газар нутагтай, хөгжил буурай улсуудад түгээмэл нөлөөлж буй нөхцөл, хүчин зүйлсийг судлан үзэхэд:

- Үндэсний эсэргүүцлийн хөдөлгөөн нь гадаад, дотоодын аюул заналхийлэлд

⁷ Монгол Улсын үндсэн хууль. УБ., 1992 он. Гуравдугаар зүйл. 1. Заалт;

⁸ Монгол Улсын үндсэн хууль. УБ., 1992 он. Арван зургаадугаар зүйл. 10. заалт;

⁹ Монгол Улсын үндсэн хууль. УБ., 1992 он. Арван долоодугаар зүйл. 4/. заалт;

¹⁰ Монгол Улсын үндсэн хууль. УБ., 1992 он. Арван есдүгээр зүйл. 3. заалт;

¹¹ Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. 2.2. заалт;

өртсөн, эсвэл өртөх нь тодорхой болж байгаа тохиолдолд улс үндэстэн өөрийн нийгэмд сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх нь өнөө үед олон улс, үндэстний өмнө тулгаран гарч ирж буй тулгар шинэ асуудал болжээ;

- Аюул занал, хүчирхийллийн төрөл, хэлбэр өөрчлөгдөж, улс үндэстний бүрэн эрхт байдал мэдээлэл-сэтгэл зүйн, кибер орон зай дахь аюул, террорист халдлага, геополитикийн орчны өөрчлөлт зэрэг хэд хэдэн хүрээнд улсын аюулгүй байдалд ихээхэн нөлөөллөөр холбогдох болов;
- Дэлхийн улсууд өөр өөрсдийн хөгжлийн замыг сонгон хөгжихдөө дэлхийн нөлөө бүхий хүчирхэг гүрний болон тэдгээрийн холбоотны аль нэгнийг дагаж байгаа нь бусдын эрх ашиг, сонирхолтой зөрчилдөж байгаа;
- Ази, Африкийн буурай хөгжилтэй, жижиг улсуудын байгалийн нөөц, баялагт олон улс үндэстэн дамнасан корпорацууд ноёрхлоо тогтоох замаар их гүрнүүдийн нөлөө үйлчилж, тэдгээр улсуудын үндэсний аюулгүй байдлын эрх ашигт хохирол учруулж, тэдэнд эсэргүүцэн сөрөн тэмцэх шаардлага, хэрэгцээг үүсгэж байгаа зэрэгт чиглэгдэх нь тодорхой байна.

Харин Монгол Улсын хувьд батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг төр, олон нийтийн байгууллагын зохион байгуулалтаар бүрдүүлэх хүчин зүйлсэд:

- Бүх нийтийн хүч, оролцоо, дэмжлэгт тулгуурлан аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаа бэхжүүлэхдээ цэргийн эвсэлд нэгдээгүй, зэвсэгт хүчнээр хүчирхэг бус улсын хувьд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх үүднээс өөрийгөө батлан хамгаалах бодлого, стратегид нийцүүлэн боловсронгуй болгох нь чухал байна;
- Орон нутгийн хамгаалалт нь өөрийгөө хамгаалах стратеги болохын үүднээс аюулгүй байдлыг хангах төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргаа, бүх нийтийн оролцоо, дэмжлэгтэйгээр үндэсний платформыг бий болгох;
- Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх нь бүсчилсэн хөгжлийн бодлого, стратегийг орон нутгийн хамгаалалтын үйл явцтай уяж, шинэ хүч хэрэгслээр зохион байгуулж хэрэгжүүлэхийг нөхцөлдүүлж байна;
- Монгол Улс томоохон газар нутагтай, эдийн засгийн боломжоор жижиг, буурай хөгжилтэй улсын хувьд ашигт малтмалын нөөц, баялаг арвинтай, уул уурхайн үйлдвэрлэлд гаднын хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэж, олон улс үндэстэн дамнасан корпорацуудын үйл ажиллагаа энэ чиглэлд ихээхэн хүч, техник технологио нэмэгдүүлж байгаа нь батлан хамгаалах аюулгүй байдлаа хангах үүднээс үндэсний эрх ашигт сөрөг нөлөөлөл үүсгэж, сөрөн эсэргүүцэн тэмцэх шаардлага, хэрэгцээг үүсгэж байгаа;
- Манай улс цахим стратегийг хөгжүүлэн хиймэл оюун ухааныг нэвтрүүлж байгаа энэ үед харилцаа холбооны сүлжээ, веб сайтуудад гаднын хакеруудын довтолгооноос үүсэх аюулын эрсдэлийг

нэмэгдүүлэх магадлал бий болж байгаа;

- Өнөө үед дэлхийн даяаршлын явцад мэдээлэл-сэтгэл зүйн болон “кибер” аюулаас үүсэх сөргөлдөөн, зэвсэгт тэмцэл өргөжин тэлэх хандлагыг агуулж, улс үндэстний язгуур эрх ашигт хохирол учруулах нь олонтоо тохиолдох болсон нь гаднын болон дотоодоос учруулах аюул занал, түрэмгийлэл нь хосолмол дайны шинж чанартай хосолж, улс оронд аюултай байдлыг нэмэгдүүлж болзошгүй байгаа;
- Үндэсний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэхдээ дэлхийн улс орнуудын туршлагыг судалж, олон улсын хүний эрхийн болон тухайн улсынхаа хууль, тогтоомжид дэмжлэг болох, байгууллага, олон нийтийн эрх ашигт нийцүүлэн сургалт, сурталчилгаа явуулах боломж, дэмжлэг, оролцоог шинжлэх ухаанч үндэслэлээр хангах хэрэгцээ шаардлагыг өндөрсгөж байгаа зэрэг багтаж байна.

Монгол Улсын аюулгүй байдлыг хангах батлан хамгаалах бодлого, стратегид дахь “байгууллага, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт”-ын тогтолцоо нь “бүх нийтийн сөрөн тэсвэрлэх чадавх” дан ганц төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаа бус төрийн болон төрийн бус хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, сайн дурын байгууллага, иргэдийн үүрэг, хүч оролцоог бүхэлд нийгмийн бүхий л үйл ажиллагааг чиглүүлж нэгтгэн хэрэгжүүлж”¹² болохоор байгаа юм.

Үндэсний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх нөхцөл, хүчин зүйлс нь “улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутаг, хил хязгаарын бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг хамгаалах эсэргүүцлийн тэмцлийн бүх арга ажиллагаанд улс нийгмийг бэлтгэх, иргэдийн оролцоотой байгууллага - иргэдийн хамгаалалт болон цэргийн хамгаалалт хоёуланд системтэйгээр цогц”¹³ байдлаар хэрэгжүүлдэг нийтлэг хандлага, шаардлагад агуулгаараа нэгдмэл байх нь чухал гэж үзэж байна.

Гурав. Улс орны батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхад Эх оронч Монгол хүн, Төр, олон нийтийн байгууллагын харилцан хамаарлын зарим асуудалд

Улс үндэсний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэхдээ “зөвхөн гаднын халдлага, уламжлалт болон уламжлалт бус ердийн цэргийн ажиллагаагаар хязгаарлагдахгүй, эдийн засаг, нийгэм рүү чиглэж, үндэсний эв нэгдлийг сулруулснаар тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутаг, хилийн бүрэн бүтэн халдашгүй дархан байдлыг хамгаалах, батлан хамгаалах чадавхыг сулруулахад чиглэдэг” болохыг онол, арга зүйн судалгаанд үндэслэлтэй хамааруулан авч үзэх шаардлагатай байна.

¹² Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх үзэл баримтлал. УБ., 2021 он. – 236 х; ЗХЖШ-аас орчуулан гаргасан гарын авлага. т.14;

¹³ Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх үзэл баримтлал. УБ., 2021 он. – 236 х; ЗХЖШ-аас орчуулан гаргасан гарын авлага. т.14;

Ялангуяа, эрх мэдлээ ашиглаж улсын төсөв, хөрөнгийг завшигчидтай, авлигатай, хүнд сурталтай, баялгийн шударга бус хуваарилалт, улс төр, бизнесийн бүлэглэлийн үйлдэлтэй тэмцэхэд хүчтэй нөлөө үзүүлж, улс орны тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэж, энэ нь байгууллага, олон нийтийн зүгээс зохион байгуулалтай хөдөлгөөн болж, Монгол Улсын батлан хамгаалах чадавхын үндэс суурийг бэхжүүлэхэд үр нөлөөгөө үзүүлэх болно гэж үзэж байна.

Улсын үндэсний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлж, хэрэгжүүлэх үндсэн байгууллага нь Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тэргүүлж, ажил арга хэмжээг зохион байгуулж явуулахдаа Зэвсэгт хүчин болон аюулгүй байдлыг хангах төрийн тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах нэгдмэл тогтолцоонд дэмжлэг үзүүлж, орон нутгийн хамгаалалтын байгууллага, нэгжийг зөвлөмж, чиглэлээр хангах замаар эх оронч сэтгэлгээ, үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэхэд төр, олон нийтийн оролцоо хосолмол статустай байх нь онцгой ач холбогдолтой юм.

Онол, практикийн арга зүйн хандлагын үүднээс судлан үзвэл эх оронч үзэл нь тухайн улс үндэсний язгуур эрх ашиг хийгээд хүн төрөлхтний язгуур ашиг сонирхлын жор нь зөв хандарсан эм тан гэж хэлж болохоор байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд: **“Улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын үзэл бодлын үндэс нь эх оронч үндэсний үзэл байна”**¹⁴ гэжээ. Ийм учраас эх оронч үзэл нь үндэсний мэдрэмж, үндэсний ухамсар, үндэсний үзэл, үндэсний бахархал, үндэсний сонирхол, үндсэрхэх үзэл зэрэг олон ойлголтуудтай уялдаж нийт иргэдэд алив аюул, заналхийллийн эсрэг сөрөн зогсох чадварыг бүрдүүлэх нөлөөллийн хамааралтай болно.

Үндэстэн нь улс төрийн эрх, эрх чөлөө бүхий ард иргэдээс бүрэлдсэн төдийгүй соёл иргэншлийн нийтлэг зорилготой хамт олон болж төлөвших нь чухал байна.

Эндээс харахад, эх оронч үзэл, үндэсний ухамсар бүрэлдэх анхны алхам нь батлан хамгаалах үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх болно. Эдүгээгийн монгол хүний үндэсний мэдрэмж, чадавхын цөм нь би монгол хүн гэдгээ, тодруулж хэлбэл өөрийгөө ухаарахуй явдал юм. Дэлхийн газар нутгийн 2.2 хувь, хүн амын 0,008 хувийг эзэлж буй 3.5 сая хүнтэй Монгол Улсын нэгэн амьд эд эс, чөлөөт зах зээлийг явуулж, ардчиллын үнэт зүйлсийг адил тэгш хүртэх, эрх, үүрэгтэй гэдгээ ухаарч эх оронч үзэл, хүмүүжлийг үндэсний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэхэд чиглүүлэх явдал билээ. Үндэстэн оршин тогтнохыг хүсвэл даяаршиж адилсахын хамт ондоосож, үндэсний өвөрмөц сөрөн тэсвэрлэх чадавхаа хадгалах учиртай болох юм. Үндэсний эх оронч үзлийн утга учир ч үүнд оршино. **Эх оронч үзэл, хүмүүжил** - үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын харилцан шүтэлцэл, хамаарал, утгын сац суварга мөн болой.

Монгол үндэстний үргэлжид тэмүүлэх байнгын үнэт зүйлс бол “Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх”¹⁵, “хүмүүнлэг, оюунлаг,

¹⁴ “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”. 1.1.2. заалт. УБ. 2010 он;

¹⁵ Монгол Улсын үндсэн хууль. УБ., 1992 он. Үндсэн хуулийн оршил хэсэг дэх заалт;

ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай, үндэсний үзэл, хүмүүжилтэй монгол хүн”¹⁶ -ийг төлөвшүүлэх явдал бөгөөд нийгмийн оршин тогтнох, түүний сайн сайхан байдал, тогтвортой хөгжил, соёлын өвөрмөц байдал, түүний хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх, тусгаар тогтнолыг ханган бэхжүүлэх чадвар, дэлхийн хамтын нийгэмлэгт улс орныхоо сөрөн зогсож, даван туулах боломжийг хадгалах чадварын илэрхийлэл байх болно.

Батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэн бэхжүүлэхэд олон нийтийн эсэргүүцлийн хөдөлгөөний гол дэмжлэг бол төр, захиргааны байгууллагаас гадна нутгийн иргэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Аливаа эсэргүүцлийн хөдөлгөөний амжилт нь иргэд хоорондын харилцан хамаарал, хамтын ажиллагааны үр дүнд бий болох бөгөөд хоол хүнс, бодит мэдээлэл, төрөл бүрийн хангалт, тагнуулын үйл ажиллагаа, хүний нөөц гэгээд нутгийн иргэдийн оролцоо чухал.

Үндэсний сөрөн тэсвэрлэх асуудал нь ард иргэдийн нийгмийн сэтгэл зүйн бэлтгэлийг хангахдаа дотоодын хямралт байдал, мөргөлдөөнөөс иргэн бүр эх орон, газар нутгаа хайрлахад чиглэсэн боловсролын эх оронч агуулгыг бодлого стратегидаа тусгаж, дайсагнагч талын суртал нэвтрүүлэгт автахгүй байх дархлааг хүүхдэд багаас нь төлөвшүүлэхээс эхлэх нь чухал байна.

Улс, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхад шаардлагатай олон үйл ажиллагаа үндэсний эсэргүүцлийн туршид үргэлжлэх бөгөөд хэлбэр, агуулгын хувьд өөрчлөгдөж, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа сэргээх хүн амын эх оронч үзэл, хүсэл зоригийг байнга нэгтгэх замаар нийгмийн ёс суртахууныг хадгалж, батжуулж байх явдал юм.

Төр засаг аюул, заналхийллийг эрт илрүүлж тодорхойлох чадвартай байж, тэдгээрээс урьдчилан сэргийлж няцаах бэлтгэлийг хангаж, шаардлагатай бол үндэсний эсэргүүцэлд цаг алдалгүй бэлтгэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхэлдэг байна. Төр улсынхаа бүрэн эрхт байдлыг хадгалах, сөрөн тэсвэрлэх чадавхад “кибер” халдлагын аюул заналхийлэл ихээхэн нөлөөлөх болжээ. Дайсагнагч этгээд цэргийн хүчний довтолгоотой зэрэгцүүлж халдах талбар нь кибер орон зай болоод байна. Кибер орон зай дахь халдлагыг илрүүлэх, хамгаалах явдал нь үндэсний эрх ашиг болон мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах үндэсний чадавхыг дэмжих онцгой арга хэмжээ болжээ.

Дэлхийн нийтийг хамарсан “Кобид -19 тахал” болон өнгөт хувьсгалууд, тэдгээрээс үүссэн эрсдэл нь хүн төрөлхтөнд учруулж болзошгүй төрөл бүрийн аюулууд, түүнийг сөрөн тэсвэрлэх чадавх хэр байгааг 2020-2022 онд тодорхой харагдсан билээ.

Энэ үед эдийн засгийн хүндрэл, улс төрийн өөрчлөлт, хүн амын өвчлөлийн халдварлалын тархалт, айдас зэрэг хэд хэдэн хямралт байдалтай тулгарсан. “Кобид -19 тахал” нь амьдрал ба үхэл, эрх чөлөө, хариуцлага, утга учиртай холбоотой хүндрэлтэй асуудлыг бий болгож, оршин тогтнох сорилт болж, улс орны сөрөн тэсвэрлэх чадавхын бодит боломжийг харуулсан нь улс нийгэм, байгууллага, иргэн

¹⁶ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Зорилт 1.2. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн. 1 үе шат (2021-2030): нэгдүгээр заалт;

бүр үүрэг хариуцлагаа нэмэгдүүлэхийн анхааруулга болсон юм.

Аливаа аюул, заналыг мэдэрч урьдчилан таамаглаж, болзошгүй аюулын эрсдэлийг даван туулах нийгмийн болон ард иргэдийн нөлөөллийн үндсийг тодорхойлох нь чухал юм.

Хүний чадавхыг хөгжүүлэх чиглэлээр дэлхийн жишигт нийцсэн судалгаа явуулахаас гадна гадаадын тэргүүлэгч байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох, боловсролын хөтөлбөрт өөрчлөлт оруулж хэрэгжүүлэх, шинжлэх ухааны технологийн дэвшилтэт дэд бүтцийг бий болгох, гарсан үр дүнг төрийн байгууллага, нэгжийн үйл ажиллагааны практикт нэвтрүүлэх шаардлага үүсэж байна.

Хувь хүний чадавх нь тухайн хүнд өгөгдсөн нөхцөлөөр хязгаарлагдахгүй, стандарт бус шийдлүүдийг олох, ямар ч нөхцөлд өөрийн итгэл үнэмшил, амьдралын утга учиртаа үнэнч байх боломжийг олгоно гэж үзэж байна.

Улс орны батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадвар бат, тогтвортой байх нь болзошгүй аюул, түрэмгийллийг няцааж, үндэсний эсэргүүцлийн хөдөлгөөн суурь хүчин зүйл болох тул хямралт нөхцөлийг даван туулах зохион байгуулалтын бэлтгэлийг хангах явдал чухал болоод байна.

Гаднын аливаа нөлөөлөл, дарамтыг тууштай сөрөн тэмцэх чадавхтай хүн амыг бүрдүүлсэн цагт үндэсний аюулгүй байдлын батлан хамгаалах дархлаа тогтож, эсэргүүцлийн хөдөлгөөн амжилттай явагдах нөхцөлийг бүрдүүлэх юм. Энэхүү нийгмийн сэтгэл зүйн дархлааг боловсролын тогтолцоонд тулгуурлан урт болон богино хугацааны сургалт-мэдлэгийн системлэг арга зүй шаардлагатай бөгөөд нийт иргэдэд эх орон газар нутгаа хайрлан хамгаалахад чиглэсэн эх оронч үзэл - хүмүүжлийг бага наснаас нь төлөвшүүлэх нь чухал юм. Үүний тулд:

- Улс үндэсний үнэт зүйл, эв нэгдэл, сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх зорилгоор эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх чиглэлээр байгууллага, ард нийтэд олон талт сургалт, сурталчилгааны ажлыг хамтын хүч хэрэгслээр эрчимтэй явуулж хэвшүүлэх;
- Улс үндэсний бахархал, эрх чөлөөний үнэ цэнэ, соёлыг бүх нийтэд хүртээл болгон дэлгэрүүлэх үйл ажиллагааг улс орны түвшинд зохион байгуулж, түнш улсууд болон олон улсын байгууллагуудтай боловсрол, соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх ажил арга хэмжээг идэвхжүүлэх;
- Дотоодын харилцан хамаарал, хамтын ажиллагааг сайжруулан бэхжүүлэх замаар төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах, иргэдийг эсэргүүцлийн тайван, хүчирхийллийн бус арга, ажиллагаанд сургаж дадлагажуулах;
- Үндэсний эв нэгдлийн илэрхийлэл болох батлан хамгаалах үндэсний сөрөн тэсвэрлэх, чадавхыг бэхжүүлэх замаар дайсагнагч талын эсрэг мэдээлэл – сэтгэл зүйн урсгалыг бий болгох явдал чухал байна.

Үндэсний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэн бэхжүүлснээр хүрэх үр дүн:

- Монгол Улсын аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах боломжийг өсгөн нэмэгдүүлэх шинэ арга зам тодорхой болно;

- Монгол Улсын орон нутгийн хамгаалалтыг бүсчилсэн хөгжлийн үзэл-стратегитай уялдуулан улам боловсронгуй болгох нэг үндэс болно;
- Монгол Улсын Зэвсэгт хүчний улсынхаа аюулгүй байдлыг хангах, эх орноо хамгаалах чадавхыг дээшлүүлэх арга замыг нэмэгдүүлэх зорилго, зорилтууд хангагдах болно гэж үзлээ.

ДҮГНЭЛТ

Үндэсний сөрөн тэсвэрлэх батлан хамгаалах чадавхыг бүрдүүлж, үндэсний эсэргүүцлийг тасралтгүй үр дүнтэй явуулах үүднээс хууль эрх зүйн баталгаа зайлшгүй чухал урьдач нөхцөл учир үндэсний эсэргүүцлийн хөдөлгөөнд бэлтгэх ажлын зохион байгуулж явуулах тухай хууль баталж, төсөв санхүүжилт, ажиллагаа явуулах эрх хэмжээ, эсэргүүцлийн хөдөлгөөнд оролцогчдын эрх зүйн асуудлын зохицуулалтыг нэн түрүүнд шийдвэрлэх нь зүйтэй юм. Энэ нь улс үндэсний батлан хамгаалах бэлэн байдал ба сөрөн тэсвэрлэх чадавхыг хүчжүүлж, өсгөн нэмэгдүүлэх болно.

Батлан хамгаалах боловсролоор дамжуулан эх орноо хайрлан хамгаалах ухамсар сэтгэхүйтэй, ёс зүйтэй, мэдлэг чадвартай эх оронч монгол хүнийг бэлтгэхийн тулд:

- Монгол хүний оюун ухаан, сэтгэл санааны хүч чадлыг танин мэдэж, бие бялдрын чадвартай хослуулан бүх нийтэд улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үзэл, чадварыг бүрэлдүүлэх;
- Улс орноо батлан хамгаалах, улс, нийгэм, хувь хүний болон байгууллагын аюулгүй байдлыг хангах арга тактикийг нийт иргэдэд бий болгож бүрдүүлэх замаар улсын батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхэд хүн бүрийн үүрэг, хариуцлага, оролцоо, боломж чухал гэдгийг ухамсарлуулан ойлгуулж, улмаар аливаа аюул, бэрхшээлийг даван туулах чадавх, хүч, нөөц боломжийг нэмэгдүүлэх;
- Иргэдэд цэргийн хэргийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх, эх оронч хүмүүжил олгох, аюулгүй амьдрах арга ухаанд сургах, дайчилгааны нөөцийн бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах, төрийн алба хаагчдад батлан хамгаалах чадавхыг бүрдүүлж нэмэгдүүлэх үүднээс тэдэнд: цэрэг, эх оронч үзэл төлөвшүүлэх сургалт; аюулгүй амьдрах ухааны сургалт; дайчилгааны бэлтгэл нөөцийг бүрдүүлэх сургалт; орон нутгийн хамгаалалтын сургалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлага байна.

Үндэсний батлан хамгаалах сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх нэн чухал арга хэмжээ бол хүн амыг хамгаалах иргэний хамгаалалтын үндсэн арга болсон нийтийн хамгаалалтын асуудал үндсэндээ 1980-д оны дунд үеэс орхигдож, өнөө хүртэл бүрдэл болоогүй байна. Үүнд, хүн амын хамгаалах зориулалттай хоргодох байр, нэг бүрийн болон нийтийн хамгаалах хэрэгслийн хангалт, сургалт бэлтгэлийг зохион байгуулж явуулах, болзошгүй аюулын үед хүн амыг нүүлгэн шилжүүлэх чиглэл, байршил байрын төлөвлөлтийг боловсронгуй болгох зэрэг олон арга

хэмжээг хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна.

Үндэсний батлан хамгаалах сөрөнтэсвэрлэх чадавхын үеийн төр, олон нийтийн байгууллага хоорондын нэгдсэн ажиллагааг төлөвлөх, бэлэн байдлыг хангах, хамтарсан сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөлтийг бүрдүүлж хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, цэргийн байгууллагын зэвсэглэл, техникийн харилцан уялдааг хангах, холбоо мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Зэвсэгт хүчний хувьд нь батлан хамгаалах чадавхыг бүрдүүлэх үүднээс болзошгүй зэвсэгт түрэмгийллийг тогтоон барих үүргээ биелүүлэхэд шаардагдах бэлтгэлийг тайван цагт хангах үндсэн үүргийнхээ зэрэгцээ, НҮБ-ийн энхийг дэмжих болон олон улсын бусад ажиллагаанд оролцох, терроризмтой тэмцэх, улсын хил, онц чухал объектыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, улс орны томоохон бүтээн байгуулалтын ажилд оролцох зэрэг олон талт үүрэг биелүүлэх чадвартай байж, олон талт тусгай үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх нь өнөөгийн зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын үндсэн үүргийн нэг болж байна.

Өнөөдөр Зэвсэгт хүчин Зэвсэгт хүчний тухай хуулиар хүлээсэн тайван цагийн нэг үүрэг болох Энхийг сахиулах олон улсын хамтын ажиллагаанд оролцох үүргийг гүйцэтгэж байгаа нь үндсэн чиг үүргээсээ хазайсан хэрэг огт биш, харин тэдгээрийн бие бүрэлдэхүүний бэлтгэлийн түвшин, бэлэн байдал, эх оронч хүмүүжил, халуун цэгт багаар ажиллах сэтгэлгээний бэлтгэл, сөрөн тэсвэрлэх чадавх нэмэгдэж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. Заалт 1.2 ба 2.1, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт;
2. “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх үзэл баримтлал” УБ., 2021 он. – 236 х; ЗХЖШ-аас орчуулан гаргасан гарын авлага;
3. Cyberwarfare, CRS Report for Congress, RL 30735, Nov. 15, 2000;
4. Батлан хамгаалах стратеги. (онол, арга зүй, шинжилгээний бүтээл). УБ., 2017 он. – 400 х;
5. Необходимое разъяснение к происходящим в Казахстане событиям – Avesta – информационное агентство. 2022 г;
6. Монгол Улсын үндсэн хууль. УБ., 1992 он. Үндсэн хуулийн оршил хэсэг дэх заалт;
7. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. I үе шат (2021-2030 он): Нэг дэх заалт;
8. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ. 2010 он.